



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/19

Шивээговь сум

**Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага  
 худалдаа явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1.Сумын 2 дугаар баг, Шивээ-Овоо хувьцаат компанийн уурхайн баруун хойд талд 30 га газрыг Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг явуулсугай.

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрыг хавсралтаар баталсугай.

3.Хавсралтанд заагдсан нэгж талбарыг батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу иргэд, олон нийтэд зарлан мэдэгдэж, журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Janjir* П.ГАНЧИМЭГ

